



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСЭЙН
2025 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2025 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАНГИЙН АГУУЛГА:**

Нэг.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Бодлого зорилтыг хангах ажлын хүрээнд	3
1.2. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:	3-3
Хоёр. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:	
2.1.Хэлтсээс зохион байгуулсан ажил,үйлчилгээ.....	3-4
2.2. Албан хаагчдын ажиллах нөхцөл,нийгмийн баталгааг хангах чиглэлээр	4-5
2.3 Тоон гарын үсэг	5
2.4. Аймаг, орон нутгийн удирдлага болон бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, хэрэгжүүлсэн ажил	5
2.5 Хэлтсээс зохион байгуулсан шинэлэг ажил	5-6
2.6 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой хийгдэж буй ажлууд	
Гурав. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР	
3.1. Ерөнхий газраас зохион байгуулсан сургалтууд:.....	6-7
3.1. Аймаг болон бусад газраас зохион байгуулсан сургалтууд	6-7
3.2. Хэлтсээс зохион байгуулсан сургалтууд:.....	7
Дөрөв. ХЭЛТСИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР.....	7-8
Тав. БИЧИГ ХЭРГИЙН ЧИГЛЭЛЭЭР:	8
Зургаа. ИРГЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:.....	8-9
Долоо. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР	10
Найм. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР	11
Ес. АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:	11-12
Арав. ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:.....	12
Арван нэг. САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:	12-15

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

2025.11.10

Алтай хот

Нэг: ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Бодлого зорилтын хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон орон нутгийн удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар, удирдамж чиглэл, тушаал, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг удирдлага болгон хэрэгжилтийг өдөр тутмын ажил, үйлчилгээнд бүрэн хэрэгжүүлж, иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг орон нутагт эрхлэн зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн Улсын бүртгэлийн үйлчилгээг **18** сум **88** багийн **58.500** гаруй иргэнд хүргэн ажиллаж байна.

1.2. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Говь-Алтай аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн “Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг батлах тухай” 2025 оны А/157 дугаар тушаалаар батлагдсан орон тооны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 1, Хяналтын улсын байцаагч 1, Тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 2, Захиргааны ахлах мэргэжилтэн 1, Улсын бүртгэгч 24, Архивч 1, Нярав, бичиг хэргийн ажилтан 1, Ахлах нягтлан бодогч 1, Архивч, мэдээллийн технологийн ажилтан 1, Гэрээт ажилтан 3 зэрэг нийт 36 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Хоёр: ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

2.1. Хэлтсээс зохион байгуулсан ажил:

➤ Төрийн захиргааны албан хаагчидтай 2025 онд хэрэгжүүлэн ажиллах гүйцэтгэлийн төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд баталж мөрдүүлэн ажиллаж байна.

➤ 2024 оны ХАСХОМ-ийг мэдүүлэх ёстой 28 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг 2025 оны 01 сарын 21-нд багтаан сүлжээнд бүрэн шивүүлж, баталгааны маягтыг гаргуулан авч баталгаажуулан хадгалсан болно. Тайлант хугацаанд авилга, ашиг сонирхолын зөрчлийн асуудлаар иргэдээс өргөдөл, гомдол, санал хүсэлт ирээгүй. Хөрөнгө орлогоо мэдүүлэхээс татгалзсан, хугацаа хожимдуулсан албан тушаалтан байхгүй.

➤ Аймгийн Төрийн Аудитын газраас Хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитын хяналт шалгалтыг түүвэрчлэн хийж ямар нэгэн акт, зөвлөмж өгөөгүй бөгөөд “Өөрчлөлтгүй” дүгнэлт гаргасан.

➤ Хэлтсийн албан хаагчдад сар бүр онлайнаар хурал зохион байгуулж цаг үеийн байдал, болон тулгамдаж буй асуудал, Аймаг орон нутгийн удирдлага, УБЕГ-аас өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр танилцуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 5 удаагийн онлайн хурал зохион байгуулсан байна. /Үүнд: УБЕГ-аас өгсөн үүрэг чиглэл, цаг үеийн ажлууд, тоон гарын үсэг олголт/

➤ Сумдад ажиллаж буй бүх улсын бүртгэгчид болон аймгийн төвийн албан хаагчдын ажлын цаг ашиглалтын байдалд хяналт тавьж 2025 оны 5 сарын 01-ны өдрөөс ERP программаар чөлөөний асуудлыг шийдвэрлэж байна.

➤ Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 85 жилийн ойд зориулсан “Спорт-2025” тэмцээнд тус хэлтсээс 5 албан хаагч амжилттай оролцлоо.

Үүнд:

-Волейбол (эмэгтэй) – Алтан медаль (Шилдэг тамирчнаар Говь-Алтай УБХ Улсын бүртгэгч Э.Цэрэндулам)

-Ширээний теннис (эрэгтэй) – Алтан медаль (Говь-Алтай УБХ гэрээт ажилтан Ч.Цэрэндаваа)

-Дартс (Эрэгтэй) Мөнгөн медаль (Говь-Алтай УБХ Улсын бүртгэгч Г. Гантулга)

➤ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх зорилгоор Хэлтсийн үйлчилгээний танхимд 1 өрөөг тохижуулан үйлчлүүлэгчийн ая тухтай үйлчилгээ авах бололцоог ханган үйлчилгээ үзүүлж байна. Уг өрөөнд харааны шил, барель үсгэн ном, томруулагч шил зэргийг байршууллаа.

➤ 2025.05.30-ны өдөр Эхийн алдар одон хүртсэн Улсын бүртгэгч Н.Золжаргалд Хэлтсийн хамт олон хүндэтгэл үзүүллээ.

➤ Эх үрсийн баярыг тохиолдуулан 2025.05.30-ны өдөр Хэлтсийн албан хаагчдын 37 хүүхдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн бэлэг гардуулав.

➤ Бүх албан хаагчидтай “Эд хөрөнгийн хариуцлагын гэрээ” хийлээ.

➤ 2025.06.09,10-ны өдрүүдэд Улсын Онцгой комиссоос тус аймагт зохион байгуулсан Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт Улсын бүртгэгч Б.Тогтохбаяр ахлагчтай Улсын бүртгэлийн хэлтсийн мэргэжлийн анги амжилттай оролцлоо.

➤ Төрийн захиргааны албан хаагчидтай Төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангуулах ярилцлагыг 1,2,3-р улиралд нэг бүрчлэн хийж , тэмдэглэлийг хөтлөн үүрэг, чиглэл өглөө.

2.2. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр:

➤ Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Говь-Алтай аймгийн иргэдийг орон сууцжуулах” хөтөлбөр, Төрийн албаны тухай хуулийн 61.1.5-д заасан орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх баталгааг эдлүүлэхтэй холбогдуулан орон сууцны дэмжлэг үзүүлэх албан хаагчийг 2025.05.01-ны өдрийн хамт олны хурлаар хэлэлцэн Улсын бүртгэгч Б.Хүрлээг уг хөтөлбөрт хамруулахаар шийдвэрлэж материалыг Аймгийн засаг даргад хүргүүлээ.

➤ Хэлтсийн албан хаагчдын шагналын судалгааг шинэчиллээ. УБЕГ-аас 2025 оны 05 сарын 07-ны өдрийн 2/6317 тоотоор ирүүлсэн чиглэлийн дагуу шагнуулах албан хаагчдыг хамт олны хурлаар хэлэлцэж, шагналын материалыг 2025 оны 05 сарын 28-ны өдрийн №09 тоотоор УБЕГ-т хүргүүлэн “Төрийн албаны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр Улсын ахлах бүртгэгч Я.Арвижих, “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр Улсын бүртгэгч С.Чинзориг “Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр шагнуулахаар Улсын

бүртгэгч Э.Түвшинзаяа, “Архивын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэгээр Архивч С.Баянаа, Хууль зүйн яамны” Жуух бичиг”-ээр Улсын бүртгэгч Д.Гүндэгмаа, Н.Гүндэгмаа, П.Алтанцэцэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын “Жуух бичиг”-ээр Улсын бүртгэгч Н.Золжаргал, Д.Алтанцэцэг нар тус тус шагнагдлаа.

➤ Хууль зүй дотоод хэргийн сайдын санаачилгаар явуулж буй “Хамгийн чухал нь” эрүүл мэндийн эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд 2025 оны 04 дүгээр сарын 02,03-ний өдрүүдэд Улсын бүртгэлийн хэлтсийн нийт албан хаагчид болон тэдний гэр бүлийн (насанд хүрсэн) гишүүдийг оролцуулан нийт 65 хүн хамрагдав.

➤ Идэвхтэй амралт, явган аялалын арга хэмжээг 2025.05 сард Тайшир сумын Гэгээн нууранд зохион байгуулж 16 албан хаагч хамрагдсан.

➤ 2025.06.09-ны өдөр УБЕГ-аас ирүүлсэн орон сууцанд орох хэрэгцээ шаардлагатай албан хаагчдын судалгааг гарган хүргүүлэх тухай үүрэг, чиглэлийн дагуу 4 албан хаагчийн судалгааг гарган хүргүүлж Улсын бүртгэгч Ч.Угтахбаяр, Ц.Пүрэвсүрэн нар орон сууц захиалан бариулах гэрээгээ хийлээ.

➤ Хэлтсийн 2 давхарт албан хаагчдын чөлөөт цагийг ая тухтай өнгөрүүлэх үүднээс 1 өрөөг тусгайлан тохижуулж ширээний теннисний ширээ, дартс, шатар зэргийг байршуулан ашиглаж байна.

2.3 Тоон гарын үсэг:

➤ Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн үйл ажиллагаа болон тоон гарын үсгийн ач холбогдлын талаар 1800 гаруй иргэнд мэдээ мэдээлэл хүргэж, цахим иргэний үнэмлэхний санах ой буюу чип, ухаалаг гар утасны аппликэйшнээр /gsign/ дамжуулан 7139 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.

➤ 2.4. Аймаг, орон нутгийн удирдлага болон бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, хэрэгжүүлсэн ажил:

➤ Улсын бүртгэлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Нээлттэй өдөрлөг арга хэмжээг 6 удаа зохион байгууллаа. Үүнд:

-2025 оны 4,5,7 саруудад Есөнбулаг сумын засаг дарга Н.Золжаргал, багийн засаг дарга нартай 5 багийн иргэдийн нийтийн хурал болон Ахмадын спорт наадмын үеэр “Нээлттэй өдөрлөг”-ийг 4 удаа,

-2025.05 –ны өдөр Аймгийн хуульчдын холбоотой хамтран Хуульчийн Поро Боно өдөрлөгийг,

-2025 оны 05 сарын 25-нд Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран “Нээлттэй өдөрлөг”-ийг Хөхморьт сумын Овгор шард Баян-Уул сумын Баянговь, Хүйсийн говь, Дарив сумын Хужирт, Хөхморьт сумын Сангийн далай, Хүйсийн говь багийн иргэдийг хамруулан тус тус зохион байгууллаа. Уг арга хэмжээнүүдийн үеэр нийт 75 иргэн, 18 хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж 612 иргэнд тоон гарын үсэг олголоо.

➤ Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран саатуулагдаж байгаа 2 иргэнд цахим иргэний үнэмлэх сунгалтын бүртгэлийг зөөврийн төхөөрөмж ашиглан газар дээр очиж хүргэлээ.

➤ Хүний эрхийг хангах ажлын хүрээнд Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай тус хамтран бичиг баримтаа үрэгдүүлсэн 11 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж бичиг баримтжууллаа.

➤ 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр Аймгийн Иргэний нийгмийн зөвлөлөөс зохион байгуулсан уулзалтанд Хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц оролцож ТББ, хувийн хэвшилтэй хамтран ажиллах талаар санал солилцож, мэдээлэл өглөө.

➤ Говь-Алтай аймгийн Төрийн архивын хэлтэс тус хэлтсийн 2007-2016 оны байнга хадгалах 41 ширхэг баримтыг цахим болон цааасан хэлбэрээр 2025.10.07 өдөр хүлээлгэн өглөө.

2.5 Хэлтсээс зохион байгуулсан шинэлэг ажил:

➤ Улсын бүртгэлийн хэлтсээс иргэдэд төрийн үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй, чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх зорилгоор 2025 оны 2 дугаар сарын 20-ны өдрөөс “УГТАХ ҮЙЛЧИЛГЭЭ”-г үзүүлж байна. Угтах үйлчилгээгээр КИОСК машинаас 2025.11.10-ны өдрийн байдлаар иргэдэд Киоск машинаар лавлагаа-4477, тоон гарын үсэг олгох-7010 үйлчилгээг тус тус үзүүлж, пос төхөөрөмжөөр төлбөр төлөх үйлчилгээг 2780 иргэн авсан байна.

2.6 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой хийгдсэн ажлууд:

➤ Нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан Говь-Алтай аймгийн Бугат, Эрдэнэ сумдын 2 хэсгийн хороонд нөхөн сонгууль явуулахаар тухай сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг УБЕГ-т хүргүүлсэн.

➤ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль болохтой холбогдуулан иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдрөөс 6 дугаар сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд зогсоох тухай шийдвэрийг иргэдэд сурталчлан ажилласан байна.

➤ УБЕГ-ын цахим сайтад 4 сарын 01-ны өдрөөс байршуулсан сонгогчийн нэрийн жагсаалтын талаар аймгийн Алтайн мэдээгээр дамжуулан иргэдэд мэдээллийг хүргэлээ. Мөн сумдын пейж хуудас, сайтад энэ талаар шейрлэж тараалаа.

➤ Нөхөн сонгууль болох Бугат, Эрдэнэ суманд сонгогчийн нэрийн жагсаалтыг хуулийн хугацаанд хүргүүлсэн.

➤ Нөхөн сонгуулийн үеэр Улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой ямарваа нэг зөрчил, асуудал гараагүй.

Гурав: СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Тус хэлтсийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэндийг хамгаалах зэрэг ажлуудын хүрээнд 2025 онд явагдах сургалт, сурталчилгааны 9 заалт бүхий төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион явуулж байна.

3.1. Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан сургалт /Танхим/

➤ 2025 оны 04 сарын 01,02-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан Удирдах ажилтны сургалтанд Хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц, Улсын ахлах бүртгэгч Б.Энхзаяа нар

➤ 2025 оны 04 сарын 17,18-ны өдрүүдэд УБЕГ-ын МТГ-аас зохион байгуулсан сургалтанд Мэдээлэл, технологийн ажилтан М.Бат-Эрдэнэ

➤ 2025 оны 05 сарын 12,13-ны өдрүүдэд УБЕГ-ын ИУБГ-аас зохион байгуулсан сургалтанд Улсын ахлах бүртгэгч Я.Арвижих, Иргэний улсын бүртгэгч Э.Түвшинзаяа нар

➤ Улсын бүртгэлийн хэлтсээс Аймгийн Насан туршийн боловсролын төвтэй хамтран Улсын бүртгэгчид болон архивч нарт “Монгол дохионы хэлний анхан шатны мэдлэг, чадвар олгох сургалтанд 11 албан хаагч

➤ 2025 оны 11 сарын 5-7-ны өдрүүдэд улсын бүртгэлийн байгууллагын санхүүгийн албан хаагчдын 2025 оны санхүүгийн тайлан гаргах онол болон дадлагажуулах сургалтанд Нягтлан бодогч Б.Алтанбагана нар тус тус хамрагдсан.

/Онлайн/

➤ 2025 оны 02 сарын 11-ны өдөр АТГ-аас зохион байгуулсан “Авлигын хор хөнөөл” сэдэвт цахим сургалтанд Улсын ахлах бүртгэгч нар болон Улсын бүртгэгч албан тушаалтай 15 албан хаагч

➤ 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр УБЕГ-ын ЭХЭУБГ-аас зохион байгуулсан чиглэл өгөх онлайн сургалтанд Улсын ахлах бүртгэгч Б.Энхзаяа, Улсын бүртгэгч П.Алтанцэцэг, Р.Лхамдулам, Д.Гүндэгмаа, Ү.Дэлгэрмаа, Д.Отгонтуул, Ц.Пүрэвсүрэн, Н.Золжаргал Г.Баасанжаргал нар

➤ 2025 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр УБЕГ-ын ЭХЭУБГ болон Нотариатын танхимын хамтран зохион байгуулсан Нотариатын зуучлалын систем нэвтрүүлэх цахим сургалтанд Улсын ахлах бүртгэгч Б.Энхзаяа

➤ 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр УБЕГ-ын ИУБГ-аас зохион байгуулсан “Мэдээллийн санд эрх нээх, хаах тухай” чиглэл өгөх онлайн сургалтанд Улсын ахлах бүртгэгч Я.Арвижих

➤ 2025 оны 09,10 дугаар сарын 15-ны өдрүүдэд УБЕГ-ын ХЭУБГ-аас зохион байгуулсан Хуулийн этгээдийн бүртгэгч нарт чиглэл өгөх онлайн сургалтанд Хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх эрх олгогдсон 11 улсын бүртгэгч

➤ 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр УБЕГ-ын ЭХЭУБГ-аас зохион байгуулсан онлайн сургалтанд Эд хөрөнгийн эрхийн бүртгэл хөтлөх эрх олгогдсон 12 улсын бүртгэгч нар

➤ 2025.08.21-ны өдөр EPR программын сургалтанд Мэдээлэл технологийн ажилтан М.Бат-Эрдэнэ

➤ 2025.10-28-ны өдөр Байгууллагын брэндбүүк хэрэглээ, ашиглалтын талаарх сургалтанд бүх албан хаагчид тус тус хамрагдсан.

3.2. Аймаг болон бусад газраас зохион байгуулсан сургалт:

➤ 2025.01.06-ны өдөр АТГ-аас зохион байгуулсан мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан цахим сургалтанд Хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц

➤ 2025.04 сарын 24, 25-ны өдөр Аймгийн Засаг даргын тамгын газар, Архивын хэлтсээс хамтран зохион байгуулсан “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан, Бичиг хэргийн эрхлэгч нарыг чадавхжуулах” сургалтанд МТА М.Бат-Эрдэнэ, бичиг хэргийн ажилтан Ц.Цэгмид нар

➤ Нягтлан бодогч Б.Алтанбагана, Хэлтсийн өмч хамгаалах комиссын дарга, Улсын бүртгэгч Б.Тогтохбаяр нар 2025.10.13, 14-ний өдрүүдэд Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим систем”-ийн программ хангамжийг ашиглалтад бүрэн нэвтрүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бий болгох арга хэмжээг хэрэгжүүлэх сургалтанд хамрагдсан.

➤ 2025.10.22-2025.10.24-ны өдрүүдэд ХЗДХЯ-ны е-accounting системийн хэрэглэгчдийн хамтарсан зөвлөгөөнд Нягтлан бодогч Б.Алтанбагана нар тус тус хамрагдлаа.

3.3. Хэлтсээс зохион байгуулсан сургалт:

➤ 2025 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр Улсын бүртгэлийн хэлтсээс “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлаар” онлайн сургалт зохион байгуулж төрийн захиргааны 23 албан хаагч

➤ 2025 оны 02 сарын 12,13-ны өдрүүдэд сумдаас хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх эрх олгогдсон Алтай, Баян-Уул, Бигэр, Дэлгэр,

Тонхил, Халиун, Цогт, Цээл, Хөхморьт, Чандмань, Эрдэнэ сумдын улсын бүртгэгчийг Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудлууд, гарч буй алдаа зөрчлийн талаархи сургалтыг зохион байгууллаа.

**Дөрөв: ХЭЛТСИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД,
НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, МЭДЭЭЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

- Цахим хаяг: <https://govi-altai.burtgel.gov.mn/>,
<https://www.gov.mn/mn/organization/govi-altai-ulsiinburtgel#news>, <https://e-mongolia.mn/org/govialtai-burtg/about>.
- Фэйсбүүк хаяг: /Говь-Алтай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс/
- Фэйсбүүк хаяг: /GAA-n UBHeltes/ болон УБЕГ-аас өгсөн үүрэг, чиглэл гэсэн групп ашиглан /байгууллагын албан хаагчид зөвхөн орох, дотоод албан бичиг, мэдээ мэдээлэл солилцох/

Вэб хуудасны хөгжүүлэлт:

- <https://e-mongolia.mn/org/govialtai-burtg/about>.
- <https://www.gov.mn/mn/organization/govi-altai-ulsiinburtgel#news>
- Дээрх 2 шинэ вэб хуудсанд тогтмол хөгжүүлэлт хийн ажиллаж байна.
- Хуудасны цэсийг нэгдсэн загварт оруулж холбогдох линкийг холбов.
- Албан хаагчдын мэдээлэл болон бусад өөрчлөлтийг тухай бүр нь шинэчилсэн.
- Вэб-д оруулах бүх цэсэнд тохирсон мэдээллүүдийг хугацаанд нь байршуулсан.
- Вэб-д оруулсан мэдээллийн линкийг байгууллагын фэйсбүүк хаягаар дамжуулан иргэдэд сурталчилж байна.

№	Вэб хуудасны ангилал	Байршуулсан мэдээний тоо
1	Санхүүгийн ил тод байдал	10
2	Хурал, сургалт семинар, хэлэлцүүлгийн зар	9
3	Жил улирлын тайлан	1
4	Нээлттэй ажлын байрны зар	1
5	Өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдал	50
6	Сар бүрийн тоон мэдээлэл	10
7	Түгээмэл асуулт хариулт	6
8	Цаг үеийн мэдээ	20
9	Видео мэдээ	12
10	Топ мэдээ	7
	Нийт байршуулсан мэдээ	126

Сурталчилгааны чиглэлээр:

- Байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээ мэдээллийг хэлтсийн цахим хуудас, фэйсбүүк хаяг болон үйлчилгээний танхимд байршуулан иргэдэд түргэн шуурхай мэдээ, мэдээлэлийг хүргэж байна.
- Есөнбулаг сумын засаг даргын тамгын газартай хамтран “Нээлттэй өдөрлөг” арга хэмжээг 3 удаа зохион байгуулан цахим иргэний үнэмлэхний санах ой буюу чип, ухаалаг гар утасны аппликэйшн /gsign/-ний талаар 220 гаруй иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэлээ.

➤ Төрийн байгууллагуудын "Нээлттэй өдөрлөг" 2025 оны 05 сарын 25-нд Хөхморьт сумын Овгор шард зохион байгуулагдаж Баян-Уул сумын Баянговь, Хүйсийн говь, Дарив сумын Хужирт, Хөхморьт сумын Сангийн далай, Хүйсийн говь багийн иргэдэд Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны онцлог, цахим үйлчилгээ, тоон гарын үсгийн ач холбогдлын талаар мэдээ, мэдээлэл өгч зөөврийн төхөөрөмж ашиглан тоон гарын үсэг олгосон.

➤ Бүртгэлийн үйлчилгээний үнэ тариф, бүрдүүлэх нотлох баримт бичиг, үйлчилгээний хөлс тушаах дансны мэдээлэл, үйлчилгээ үзүүлэх улсын бүртгэгчийн мэдээлэл, үйлчилгээ авах цэг, хаяг байршлыг агуулсан самбарыг үйлчилгээний танхимд байршууллаа.

➤ Тус хэлтсээс Ташир сумын иргэдэд, Улсын бүртгэлийн хөдөлгөөнт баг "Явуулын үйлчилгээ"-г үзүүлсэн. Уг арга хэмжээний хүрээнд 35 иргэнд тоон гарын үсэг олгож, 4 иргэнд Улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн 120 иргэнд байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлчилгээний талаар мэдээлэл хүргэж ажилласан.

➤ Улсын бүртгэлийн байгууллагын "Брэндбүүк" шинэчлэгдсэнтэй холбоотой доорх ажлууд хийгдсэн. Үүнд:

- Брэндбүүкийн шинэ загварыг албан хаагчдад танилцуулж цаашдаа хэрхэн ашиглах талаар зөвлөмж өгсөн.
- Байгууллагын албан хэрэглээний баримт бичгийн загварыг шинэчлэв (лого, гарчиг, хуудасны загвар гэх мэт).
- Албан ёсны цахим хуудсанд шинэ лого, өнгөний шийдлийг нэвтрүүлсэн.
- Байгууллагын дотоод орчны таних тэмдэг, тэмдэглэгээг шинэчилж, гадна хаягт хэрэгжүүлсэн.
- Нэгдсэн хэв маягаар сошиал контент, видео, танилцуулга оруулсан..

Үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

➤ Албан хаагчдын компьютерийн плаш оролтуудыг бүрэн хааж, аюулгүй байдлын санамжийг компьютер болгон дээр наасан.

➤ Албан хаагчдын ашиглаж байгаа компьютер болон програмуудын нууц үгийг 14 хоногоос 1 сарын дотор солиулж, хяналт тавин ажиллаж байна.

➤ Хэлтсийн архив, сүлжээ сервер болон үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор үйлчилгээний заал, коридор, архивын гадна дотор хаалга, сургалтын заал зэрэгт 4 камер байршуулсан.

➤ Хэлтсийн үйл ажиллагаанд ашиглагддаг 9 компьютерийг **Kaspersky** вирусны жилийн лицензтэй программаар хамгаалсан.

➤ Бигэр, Гуулин, Шарга, Чандмань, Жаргалан, Цээл, Цогт сумдын сүлжээний төхөөрөмж (router)-ийн тохиргоо тогны хэлбэлзлээс шалтгаалан алдагдсан байсан тул шалгаж, дахин тохируулан хэвийн ажиллагааг хангаж ажилласан.

➤ Гуулин тосгоны 3 үйлдэлт принтерийн тэжээлийн блок шатсаныг шинэчилж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг бүрэн хангаж ажиллав.

➤ Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, байгууллагын дотоод сүлжээ, мэдээллийн системийг гаднын халдлага, халдвар, зөвшөөрөлгүй нэвтрэлтээс хамгаалах зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн Fortinet брэндийн Firewall төхөөрөмжийг байгууллагын сүлжээний нэгдсэн хамгаалалтын шийдэл болгон суурилуулж тохиргоо хийлгэн ажиллагаанд оруулсан.

Тав. БИЧИГ ХЭРГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

➤ 2025 онд тус хэлтэст 911 албан бичиг ирсэн. Үүнээс 546 хариутай албан бичгийг хуулийн хугацаанд 100% шийдвэрлэн хариуг хүргүүлсэн. Үүнд: Хууль,

хяналтын байгууллагад 356, АЗДТГ-т 71, УБЕГ-т 72, бусад байгууллагад 47 албан бичгийг хүргүүлсэн байна. 28 албан бичиг шийдвэрлэх шатандаа явж байна. Үүрэг чиглэл, шийдвэр, гадаад паспорт хүргүүлсэн гэх мэт хариугүй 365 албан бичгийг ирсэн. 228 албан бичгийг боловсруулан холбогдох албан тушаалтан, иргэдэд хүргэж ажилласан. Тус хэлтэст иргэн, хуулийн этгээдээс нийт 52 өргөдөл, санал, хүсэлт ирүүлснээс 50 өргөдлийг шийдвэрлэн иргэдэд хариуг хүргүүлсэн. 2 өргөдөл шийдвэрлэх шатандаа судлагдаж байна.

Зургаа. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

➤ 2025 онд төрсний бүртгэл 786, гэрлэлт 168, үрчлэлт 2, эцэг тогтоолт 41, овог нэр нэр өөрчлөлт 50, нас баралт 274, гэрлэлт цуцлалт 30, иргэний үнэмлэх шинээр болон дахин 2324, бусад аймаг хотоос шилжин ирсэн 268, аймаг доторх шилжилт хөдөлгөөний бүртгэл 1044 тус тус хөтөлж, бүртгэл тус бүрийн хуульд заасан нотлох баримт 9328 хуудсыг цахимжуулсан. Үндэсний энгийн болон цахим гадаад паспорт авах 2328 иргэний хүсэлтийг хүлээн авч баталгаажуулан Иргэний Улсын бүртгэлийн газарт илгээж, хэвлэгдэн ирсэн гадаад паспортыг иргэдэд олгон, нотлох баримтыг цахимжуулсан.

➤ Архив, лавлагаа олголт: Иргэд, хуулийн этгээд болон албан хэрэгцээнд зориулж 3885 лавлагаа олгосноос иргэдэд 2368, хууль хяналтын байгууллагын албан тоотой 1167, албан хэрэгцээнд 250 лавлагааг тус тус олгосон байна. Иргэний баримтын архивын хувийн хэргийн санд 826 иргэний хувийн хэргийг шинээр үүсгэж, ИУБ-11, ИУБ-18 маягт 3798 ширхэгийг төрөлжүүлэн байршууллаа. Бусад аймаг хотруу шилжин явсан 187 иргэний хувийн хэргийг ялган шилжүүлж, аймаг хотоос шилжин ирсэн 59 иргэний хувийг галиглан байршуулсан.

Хяналтын улсын байцаагчийн нэгдсэн дүгнэлтийг үндэслэн Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд засвар өөрчлөлтийн 1076 бүртгэлд засвар хийж зөрчлийг арилгасан.

Тоон гарын үсэг 7139 иргэнд олгосон байна.

Долоо. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

➤ 2025 онд иргэн, хуулийн этгээдийн Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 3627 мэдүүлэг хүсэлтийг хуулийн хугацаанд 100% шийдвэрлэв. Үүнд газраас бусад үл хөдлөх хөрөнгө анх удаа өмчлөх эрхийн 95, шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийн 154, төрөөс хувьчилсан газар өмчлөх эрхийн 40, худалдах худалдан авах гэрээгээр өмчлөгч өөрчлөгдөх 346, бэлэглэх гэрээгээр өмчлөгч өөрчлөгдөх 114, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх 57, хамтран өмчлөгч өөрчлөгдөх 35, өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээгээр шинэ бүртгэл үүсэх 76, бусад хэлбэрээр өмчлөх эрх шилжих 2, шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх 1, арилжих гэрээгээр өмчлөх эрх шилжих 2, барьцаат зээлийн гэрээний 1444, барьцаат зээлийн гэрээ дуусгавар болгох 1063, лавлагаа хуулбар олгох 4, бүртгэлд өөрчлөлт оруулах 152, бусад гэрээний 2, гээгдүүлсэн болон гэмтээсэн гэрчилгээ дахин олгох 14, бүртгэл хаах 26 бүртгэлийг тус тус хийж гүйцэтгэлээ. Эрх олгогдсон 11 сумын улсын бүртгэгч нар эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр нийт 294 мэдүүлэг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Найм. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

➤ Тайлангийн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс 750 мэдүүлэг хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Үүнд:

Шинээр байгуулсан Хязгаарлагдмал хариуцлагатай компани 73, төрийн бус байгууллага /НҮТББ, ГҮТББ/ 10, хоршоо 54, үйлдвэрчний эвлэл-6 тус тус бүртгэсэн байна. Мөн Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл 179, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт 159, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгосон 35, хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа хуулбар олгосон 69, хуулийн этгээд татан буулгасан бүртгэл 8, улсын бүртгэлээс хасахтай холбоотой хүсэлт 8 тус тус бүртгэж шийдвэрлэсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.3 т заасны дагуу тус аймагт үйл ажиллагаа явуулах 1 хуулийн этгээдийн салбарыг шинээр бүртгэж, нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 4 тус тус бүртгэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/216 тоот тушаалаар батлагдсан “Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам”-ын дагуу Хуулийн этгээдтийн тамга, тэмдэгийн хяналтын хуудас 116 олгож, хуулийн этгээдийн 34 тамга, тэмдгийг хураан авч хүчингүй болгосон. 2025 онд Улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлсөнд 14.730.000 төгрөгийг улсын төсөвт тушаалгасан байна.

Ес. АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын чиглэлээр:

➤ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт шинээр нээсэн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 296, газар өмчлөх эрхийн 36 хувийн хэрэг буюу нийт 332 хувийн хэрэг хүлээн авч бүртгэл хөтлөн байршуулсан. 2025 оны 11 сарын 10-ны өдрийн байдлаар газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 6232, газар өмчлөх эрхийн бүртгэлийн 5183 буюу нийт 11.415 хувийн хэрэг хадгалагдаж байна. 1558 хувийн хэргийн эх нотлох баримтыг бүртгэгч нараас хүлээн авч хувийн хэрэг тус бүрт хийсэн. Одоогийн байдлаар тус архивт байнга хадгалах бүртгэлийн дэвтэр 245 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын чиглэлээр:

Хуулийн этгээдийн архивт 2025 оны 11 сарын 10-ны өдрийн байдлаар шинээр бүртгэл үүссэн 148 хуулийн этгээдийн хувийн хэргийг хүлээн авч бүртгэн архивт байршууллаа. Үүнд: ХХК-80, Нөхөрлөл-9, Хоршоо-55, ТББ-11, ТБАГ-1, ОНӨТҮГ-1 шинээр бүртгэгдсэн байна. Татан буугдсан 7 хуулийн этгээдийн хувийн хэргийг ялгаж байршуулсан бөгөөд Улсын бүртгэгчээс 132 эх нотлох баримтыг хүлээн авч хувийн хэрэгт байршуулсан.

Тус архивт татан буугдсан хуулийн этгээдийн хувийн хэрэг 173 хадгаламжийн нэгж, Тамга тэмдэг хураасан тухай баримт 24 хадгаламжийн нэгж, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 39 аж ахуй нэгжийн хувийн хэрэг тус тус хадгалагдаж байна. Тус архивт нийт 2218 хувийн хэрэг хадгалагдаж байна.

Иргэний улсын бүртгэлийн архивын чиглэлээр:

Тус архивт 11 сарын 10-ны өдрийн байдлаар 3798 ширхэг ИУБ маягт хүлээн авч цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан сан тус бүрт байршуулсан. шилжин явсан 187 ХААТР маягтыг архивын сангаас татан авч харъяа газарт нь хүргүүлсэн. Шилжин ирсэн 59 иргэний хувийн хэргийг хууль журмын дагуу хүлээн авч бүртгэл хөтлөн цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан архивт байрлуулсан. Мөн 120 иргэний хүсэлтээр архивын баримтнаас төрөлт, гэрлэлт, нас баралтын лавлагаа шүүсэн. Мэдээллийн санд засвартай 1000 иргэний маягтыг хувийн хэргээс шүүж буцаан байршуулсан.

Бусад ажлууд:

Иргэн, Эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн архивын хувийн хэргийн мэдээг сар бүр гаргаж УБТА-т хүргүүлсэн. УБЕГ-ын УБТАрхиваас ирсэн чиглэлийн дагуу 2025 онд устгах бичгийн түүвэр жагсаалт үйлдэн байгууллагын ББНШК-ын хурлаар оруулан хэлэлцүүлж саналыг хугацаанд нь хүргүүлсэн. Архивын баримтын тоо бүртгэлийг хөтлөж байнга, түр хадгалах хадгаламжийн нэгжийн жагсаалт, ХХНЖ зэргийг гарган ББНШК-ын хурлаар батлуулав. 2024 онд устгахаар ялгасан баримтуудыг УБЕГ-аас ирсэн зөвлөмжийн дагуу устгаж акт үйлдэн тайланг УБТАрхивт хүргүүлсэн. 2024 оны архивын хадгалалт хамгаалалтын нэгдсэн тоо мэдээ, иргэний бүртгэлийн архивт хадгалагдаж байгаа хувийн хэрэг хадгаламжийн нэгжийн тоог нэгтгэн гаргаж УБНА-т хугацаанд нь хүргүүлсэн. Төрийн байгууллагын Архивын албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангаж, тус үзлэгээр 86,7 хувьтай үнэлэгдлээ.

Арав. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

➤ Тайлант хугацаанд өргөдөл, санал, гомдлын мөрөөр 44 удаагийн шалгалт хийсэн. Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэл, улсын бүртгэлийн архивын лавлагаа олгосон нийт 407 бүртгэлд хяналт тавьж, 261 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажиллалаа.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 27, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 17, нийт 44 дүгнэлт гаргаж, биелэлтийг хангуулж ажилласан.

Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд 181 гомдол мэдээллийг хүлээн авч, Прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн, хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж, 3.630.000 төгрөгөөр торгох шийтгэл ноогдуулсан.

Арван нэг. САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Нэг. Төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл:

2025 онд бүртгэлийн үйлчилгээний орлого 95.0 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлэх бөгөөд 10 дугаар сарын байдлаар 100.5 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 106 хувийн биелэлттэй байна.

Хоёр. Төсөв, санхүү

2025 оны 11 дүгээр сарын 12-ны байдлаар **1,571,591,100.00** төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч **1,411,759,030.19** төгрөгийг зориулалтын дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж ажилласан.

Төсвийн гүйцэтгэл, зарцуулалт /2025 оны 11 дүгээр сарын 12-ны байдлаар/

Үзүүлэлт	Батлагдсон төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
НИЙТ САНХҮҮЖИЛТ	1,571,591,100.00	1,571,591,100.00	0
НИЙТ ЗАРЦУУЛАЛТ	1,571,591,100.00	1,411,759,030.19	159,832,069.81
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,324,557,800.00	1,182,278,400.00	142,279,400.00
Үндсэн цалин	627,209,200.00	615,234,409.00	11,974,791.00
Нэмэгдэл	426,916,200.00	333,724,198.00	93,192,002.00
Унаа хоолны хөнгөлөлт	212,961,300.00	175,848,742.00	37,112,558.00
Урамшуулал	57,471,100.00	57,471,051.00	49.00
Ажил олгогчоос нийгмийн	161,044,700.00	145,417,130.19	15,627,569.81

даатгал			
Нийгмийн даатгалын шимтгэл	109,651,700.00	101,310,800.79	8,340,899.21
Тэтгэмжийн даатгал	12,900,100.00	11,665,615.83	1,234,484.17
ҮОМШ-ний даатгал	6,450,300.00	5,832,808.15	617,491.85
Ажилгүйдлийн даатгал	6,408,400.00	5,321,581.26	1,086,818.74
Эрүүл мэндийн даатгал	25,634,200.00	21,286,324.16	4,347,875.84
Байр ашиглалттай хол тогтмол зардал	57,192,600.00	55,268,400.00	1,924,200.00
Гэрэл, цахилгаан	9,936,500.00	8,012,444.27	1,924,055.73
Түлш, халаалт	42,505,400.00	42,505,275.73	124.27
Цэвэр, бохир ус	4,750,700.00	4,750,680.00	20.00
Хангамж, бараа материалын зардал	17,218,200.00	17,217,800.00	400.00
Бичиг хэрэг	11,029,100.00	11,029,000.00	100.00
Тээвэр, шатахуун	588,300.00	588,250.00	50.00
Шуудан, холбоо, интернэт	3,215,400.00	3,215,250.00	150.00
Хог хаягдал зайлуулах, хортон	318,200.00	318,200.00	0.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх,	2,067,200.00	2,067,100.00	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	3,289,100.00	3,289,000.00	100.00
Багаж, техник, хэрэгсэл	349,000.00	349,000.00	0.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	125,100.00	125,000.00	100.00
Урсгал засвар	2,815,000.00	2,815,000.00	0.00
Томилолт, зочны зардал	0	0	0.00
Дотоод албан томилолт	0	0	0.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	5,310,300.00	5,310,100.00	200.00
Бусад нийтлэг АҮТХураамж	4,688,200.00	4,688,100.00	100.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ	622,100.00	622,000.00	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	80,100.00	80,000.00	100.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	80,100.00	80,000.00	100.00
Холбооны суваг ашигласны хөлс	1,980,000.00	1,980,000.00	0.00
Бусад нийтлэг АҮТХураамж	1,980,000.00	1,980,000.00	0.00
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	918,300.00	918,200.00	100.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай а/у	0	0	0.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	918,300.00	918,200.00	100.00
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	159,832,069.81	159,832,069.81

Гурав. Өглөг, авлагын талаар:

Төсвийн гүйцэтгэл, зарцуулалтын хувьд баталсан төсвийн хуваарийн дагуу явж байгаа бөгөөд Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 27 дугаар тогтоолоор халаалтын төлбөрт өөрчлөлт орж нэмэгдсэн тул уг шийдвэрийг УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлэн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн бөгөөд 2025.11.12-ны байдлаар ямар нэгэн өглөггүй ажиллаж байна. Мөн ямар нэгэн авлага үүсээгүй болно.

Дөрөв. Нэмэлт санхүүжилтын талаар:

2025 оны 5 сард Улсын бүртгэлийн ерөнхий газраас Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд 2,567,500.00 төгрөгийн нэмэлт санхүүжилт авч 2,567,500.00 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан.

Тав. Аудит, хяналт шалгалтын байгууллагаас хийсэн шалгалтаар зөрчил дутагдалгүй ажилласан байдал, НББОУС, холбогдох хууль тогтоомж, заавар, журам мөрдөж ажилласан байдал

Аймгийн Төрийн аудитын газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн №51 тоот албан бичгээр тус хэлтсийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан бөгөөд аудитаар алдаа зөрчил илрээгүй бөгөөд ямар нэгэн зөвлөмж, акт, албан шаардлага өгөөгүй болно.

Зургаа. Тайлан мэдээ

2025 оны 11-р сарын байдлаар тус хэлтэс сар, улирал, өдөр тутам гаргах тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж харъяалагдах байгууллагад хүргүүлж ажилласан.

Үүнд:

1. Тус хэлтсийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сарын бүрийн 2-ны өдрийн дотор Төрийн сангийн хэлтсээр баталгаажуулан УБЕГазрын Санхүү, аж ахуйн хэлтсийн нягтлан бодогч А.Наранцэцэг [/a.narantsetseg@burtgel.gov.mn/](mailto:a.narantsetseg@burtgel.gov.mn), С.Ганцэцэг [/s.gantsetseg@burtgel.gov.mn/](mailto:s.gantsetseg@burtgel.gov.mn) нарт цахим шуудангаар хүргүүлсэн.
2. Үнэт цаасны тайлан мэдээг сар бүрийн 5-ны өдрийн дотор УБЕГазрын Санхүү, аж ахуйн хэлтсийн нягтлан бодогч Ц.Ганчимэгт ts.ganchimeg@burtgel.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн.
3. 2024 оны жилийн эцэс, 2025 оны 1, 2, 3-р улирлын санхүүгийн тайланг дараа сарын 15-ны өдрийн дотор УБЕГазрын Санхүү, аж ахуйн хэлтсийн нягтлан бодогч А.Наранцэцэг [/a.narantsetseg@burtgel.gov.mn/](mailto:a.narantsetseg@burtgel.gov.mn), С.Ганцэцэг [/s.gantsetseg@burtgel.gov.mn/](mailto:s.gantsetseg@burtgel.gov.mn) цахим шуудангаар хүргүүлж, сангийн яамны Э тайланд шивж нэгтгүүлэн ажилласан.
4. Тус хэлтсийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг сар бүрийн 5-ны дотор бэлтгэн гаргаж Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн.
5. 2024 оны 4-р улирал, 2025 оны 1, 2, 3-р улирлын ХХОАТ-н тайланг гарган дараа сарын 15-ны өдрийн дотор Аймгийн Татварын хэлтэст хүргүүлсэн.

Долоо. Төсвийн ил тод нээлттэй байх зарчим, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хийсэн ажил

Байгууллагын үйл ажиллагаа болон төсөв, санхүүгийн гүйцэтгэлийг хэлтсийн байрны мэдээллийн самбарт тухай бүр байршуулсан.

2025 оны 11-р сарын байдлаар Шилэн дансны тухай хуулийн дагуу <https://info.shilendans.gov.mn/> цахим хуудсанд 143 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бөгөөд хугацаа хоцорсон, огт оруулаагүй мэдээлэл байхгүй бөгөөд

2024 оны 4-р улирал, 2025 оны 1, 2, 3-р улирлын мэдээллийг хугацаанд нь илгээсэн.

Найм. Үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хөрөнгө оруулалт.

2025 оны эхэнд барилга, авто машин, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, програм хангамж гэсэн 5-н бүлгийн 815,445,861.00 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байсан бөгөөд 2025.11.12-ны байдлаар 819,106,441.00 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын өмчийн бүртгэлийн программд 2024 оны өөрчлөлтийн бүртгэлийг хийж хугацаанд илгээсэн.

Тус хэлтэс нь орон сууцны 3 өрөө байртай ба одоогоор ямар нэг үйл ажиллагаа явагдаагүй байна.

Хэлтсийн албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг хүн тус бүрээр хөтөлж байна.

Ес. Бараа материалын бүртгэл хөтлөлт, тайлагнасан байдал

➤ Улсын бүртгэгч нарын үнэт цаасны тайланг авч нэгдсэн тайланг гаргаж ажилладаг ба Улсын бүртгэгч нараас ирүүлсэн үнэт цаасны тайланд тусгагдсан хүчингүй болсон үнэт цаасыг сар бүр хүчингүй болгосон акт үйлдүүлэн хяналтын улсын байцаагчаар хүчингүй болгуулан ажиллаж байна.

➤ Аж ахуйн материал, бичиг хэрэг, бэлэн бүтээгдэхүүн, бусад бараа материалын тайланг сар бүр няраваар гаргуулан хяналт тавьж ажиллалаа.

Арав. Бусад

➤ 2025.10.15-нд байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг хуралдуулж 2025 оны жилийн эцсээр тэг үлдэгдэлтэй байгаа үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгаж шинэ үнэ тогтоох болон актлан хөрөнгийн шийдвэрийг гаргаж УБЕГазрын Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлсэн.

ХЯНАСАН:

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Г.ЧҮЛТЭМЖАМЦ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЖИЛТАН М.БАТ-ЭРДЭНЭ